



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Архангайн ус суваг” ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2025/007/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: www.audit.mn
Архангай аймаг
2025 он

Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа
Утас: 7033-3141

Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn
Аудитын менежер Д.Нэргүйбаатар
Утас: 7033-2860

Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn
Ахлах аудитор Н.Алтантуяа
Утас: 7033-3019
Цахим хаяг: Altantuyan@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2025.05.21 № 155
танай _____ -ны № _____ -т

АРХАНГАЙН УС СУВАГ ОРОН
НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРАЛ Б.ЭНХСАЙХАН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Архангайн ус суваг” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол “Архангайн ус суваг” ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, тодруулга Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй алдаа, зөрчлүүд нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө нь дангаараа болон нийт дүнгээрээ өргөн тархаагүй гэж үзсэн тул Хязгаарлалттай дүгнэлт хүргүүлж байна. Үүнд:

1. Тайлант онд орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй, алдагдалтай ажилласан.
2. Татварын өглөг 51,030.1 мянган төгрөгийг барагдуулаагүй.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20.3 дахь заалтуудыг зөрчсөн бөгөөд аудитын эрх ба үүрэг, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	99,033,634.28	15,006,122.35
1.1.02	Дансны авлага	35,952,121.93	24,341,096.95
1.1.04	Бусад авлага	50,946,627.42	47,777,409.60
1.1.06	Бараа материал	202,016,448.54	161,578,000.59
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	387,948,832.17	248,702,629.49
1.2.01	Үндсэн хөрөнгө	1,237,804,205.65	16,936,622,455.46
1.2.02	Биет бус хөрөнгө	3,401,310,000.00	3,399,510,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,639,114,205.65	20,336,132,455.46
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,027,063,037.82	20,584,835,084.95
2.1.1.01	Дансны өглөг	166,938,120.60	171,022,952.62
2.1.1.03	Татварын өр	39,599,348.52	63,809,599.63
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	7,596,174.46	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	214,133,643.58	234,832,552.25
2.1.2.01	Урт хугацаат зээл	1,367,000,000.00	11,211,764,698.88
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	299,950,339.10	0.00
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,666,950,339.10	11,211,764,698.88
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,881,083,982.68	11,446,597,251.13
2.3.01	Өмч: - төрийн	351,271,342.52	351,271,342.52
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	206,573,729.30	206,573,729.30
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	3,572,348,601.00	11,351,279,988.98
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-984,214,617.68	-2,770,887,226.98
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-251,858,056.66
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-984,214,617.68	-2,519,029,170.32
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,145,979,055.14	9,138,237,833.82
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	5,027,063,037.82	20,584,835,084.95

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
01	Борлуулалтын орлого (цэвэр)	1,572,403,351.89	1,700,517,041.55
02	Борлуулалтын өртөг	1,598,218,022.39	1,777,343,234.41
03	Нийт ашиг(алдагдал)	-25,814,670.50	-76,826,192.86
05	Хүүний орлого	20,174,672.57	20,757.76
08	Бусад орлого	8,860,806.81	17,462,801.82
08.1	Орлогын дүн	29,035,479.38	17,483,559.58
10	Ерөнхий ба удирдлагын зардал	135,878,671.50	134,611,887.14
12	Бусад зардал	5,562,363.63	8,145,454.54
12.1	Зардлын дүн	141,441,035.13	142,757,341.68
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	-49,607,785.93
17	Бусад ашиг (алдагдал)	-12,585,400.00	-148,220.00
17.1	Олз, гарзын дүн	-12,585,400.00	-49,756,005.93
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-150,805,626.25	-251,855,980.89
19	Орлогын татварын зардал	4,109,590.26	2,075.77
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-154,915,216.51	-251,858,056.66
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-154,915,216.51	-251,858,056.66

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,760,007,471.13	1,921,099,521.52
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,760,007,471.13	1,910,099,521.52
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	11,000,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,932,254,668.10	1,993,487,791.21
1.2.1	Ажиллагчдад төлсөн	654,068,895.61	820,328,188.62
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	198,779,884.38	226,290,282.21
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	313,167,960.00	190,808,593.30
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	350,198,406.66	366,624,998.06
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	192,937,756.00	134,800,694.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	143,748,091.26	215,528,351.76
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	580,987.00	1,878,605.11
1.2.9	Бусад мөнгөн зарлага	78,772,687.19	37,228,078.15
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-172,247,196.97	-72,388,269.69
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	20,174,672.57	20,757.76
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	20,174,672.57	20,757.76
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	11,660,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	11,660,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	20,174,672.57	-11,639,242.24
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	68,000,000.00	0.00
3.2.5	Бусад	68,000,000.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-68,000,000.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-220,072,524.40	-84,027,511.93
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	319,106,158.68	99,033,634.28
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	99,033,634.28	15,006,122.35

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр /

№	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2022 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	351,271,342.52	206,573,729.30	3,395,610,000.00	-1,137,534,849.79	2,815,920,222.03
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	308,235,448.62	308,235,448.62
03	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-154,915,216.51	-154,915,216.51
06	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	176,738,601.00	0.00	176,738,601.00

09	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	351,271,342.52	206,573,729.30	3,572,348,601.00	-984,214,617.68	3,145,979,055.14
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	-1,534,814,552.64	1,534,814,552.64
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	-251,858,056.66	-251,858,056.66
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	7,778,931,387.98	0.00	7,778,931,387.98
17	2024 оны 12 сарын 31-р үлдэгдэл	351,271,342.52	206,573,729.30	11,351,279,988.98	-2,770,887,226.98	9,138,237,833.82

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн аудитаар 1,236,018.1 мянган төгрөгийн алдаа¹ 3 алдаа илэрч санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ. Үүнд:

- Аймгийн ИТХ-ын 2024 оны 04 дүгээр сарын 29-ны 08 дугаар тогтоол болон Орон нутгийн өмчийн газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 25-ны А/39 тоот тушаалыг үндэслэн Орон нутгийн өмчийн газарт бүртгэлтэй 20 нэр төрлийн 9,099,752.7 мянган төгрөгийн өртөг бүхий цэвэрлэх байгууламж болон туслах барилга байгууламжийг аймгийн Орон нутгийн өмчийн газраас шилжүүлэн авч бүртгэхдээ хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 1,025,337.7 мянган төгрөгийг Азийн хөгжлийн банкны урт хугацаат зээлийг бууруулж бичилт хийснийг аудитын явцад залруулав.
- Аймгийн ОНХС-ийн 199,680.4 мянган төгрөгөөр хийгдсэн Авто худаг, усны төвийг орлогод авч бүртгээгүйг бүртгэл тайланд тусгуулан аудитын явцад залрууллаа.
- Аймгийн гамшгийн зардлаас универсаль трактор засварт 11,000.0 мянган төгрөг олгосныг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй байсныг аудитын явцад орлогоор бүртгүүлж залрууллаа.

Дээрх алдаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг”, 14.4.3-т “бүх өр төлбөрийг”, 14.4.5-т “бүх орлогыг” нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ гэсэн заалтууд болон аудитын үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар залруулагдаагүй нийт 60,072.9 мянган төгрөгийн зөрчил² илэрч, 4 албан шаардлага хүргүүлээ.

Аудитаар илэрсэн 60,072.9 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдал 12,026.0 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1. Нийт орлогыг 2,063,688.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 1,718,003.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, төлөвлөгөөг 16.7 хувиар буюу 345,687.4 мянган төгрөгөөр тасалсан буюу дутуу бүрдүүлсэн .

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан **биелэлтийг хангах**”, ТУЗ-ийн 2024 оны 05 дугаар сарын 17-ны 02 дугаар тогтоолын 2 дахь заалттай нийцэхгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх

3.2.2. Цалин хөлсний анхан шатны баримтыг хянаж үзэхэд зарим саруудын ажлын цагийн бүртгэлийг бүрэн хөтөлж баталгаажуулаагүй, хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “ Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5.-т "Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.2.3. Ус ашигласны татвар 6,903.7 мянган төгрөг, ХХОАТ-ын өглөг 6,614.2 мянган төгрөг, НӨАТ-ын өглөг 18,194.1 мянган төгрөг, татварын хяналт шалгалтын акт, торгуулийн өр 19,318.2 мянган төгрөг, нийт 51,030.1 мянган төгрөгийг өр төлбөрийг барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2.4. Нийтийн аж ахуйн баярт зориулж байгууллагын төсвөөс 9,042.8 мянган төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1 -д " Зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, өндөр сахилга баттайгаар зохион байгуулах", 4.2.6-д "Үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

.....ооо.....

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
УХӨТ-ийг бууруулж бүртгэсэн	1	1025337.7			1	1025337.7	1	1025337.7				
Хөрөнгийг бүртгээгүй орхигдуулсан	1	199680.4	1	199680.4			1	199680.4				
Орлого бүртгээгүй	1	11000.0	1	11000.0			1	11000.0				
Нийт дүн	3	1236018.1	2	210680.4	1	1025337.7	3	1236018.1				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Орлогыг бодитой төлөвлөөгүй, орлогыг төлөвлөгөөг биелүүлээгүй	1	0			1	0						
Өр төлбөрийг барагдуулаагүй	1	51030.1			1	51030.1						
Ажлын цагийн бүртгэл хөтлөлт хангалтгүй	1	0			1	0						
Арвилан хэмнэлтгүй зарцуулсан	1	9042.8			1	9042.8						
	4	60072.9			4	60072.9						